

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6139 : 2010
Seedlings of coniferous trees. Technical requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2010 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь ойн бүсийн ургах орчны нөхцөлөө хэт алдсан ойгоор бүрхэгдээгүй ойн талбайг ойжуулах (шинэс, нарс, гацуур, хуш, жодоо), ойт хээрийн бүсэд орших хот, суурин газрын ногоон байгууламжинд зориулан (нарс, шинэс, гацуур) мод үржүүлгийн газарт бойжуулсан болон ойгоос авах суулгацыг сонгон ухаж авах, хамгаалах, савлах, тээвэрлэх, суулгахад хамаарна.

2 Техникийн шаардлага

2.1 Ойгоос авах шилмүүст модны суулгацыг хэмжээ, чанараар нь 1, 2, 3 дугаар зэрэг гэж ангилсан ба зэрэг тус бүр нь 1-р хүснэгтэд дурьдсан шаардлагыг хангасан байна.

2.2 Мод үржүүлгийн газарт бойжуулан ургуулсан шилмүүст модны суулгацыг нас, хэмжээгээр нь 1, 2 дугаар зэрэг гэж ангилан 2-р хүснэгтэд оруулав.

2.3 Ой ба мод үржүүлгийн газраас суулгацыг ухаж авахдаа урд зүг буюу нар харсан талд нь (даавуу, утас уях зэрэг) тэмдэг тавьсан байна.

2.4 Үндэстэй нь хамт авсан шорооны чийгийг алдагдуулж болохгүй.

2.5 Суулгацыг газар гэссэний дараа 4-р сарын 20-оос 5-р сарын 25 хүртэл, ургалт зогссоны дараа 9-р сарын 25-аас 11-р сарын 1-ний дотор тус тус суулгана.

**Ойгоос авах шилмүүст модны суулгацад
тавих шаардлага**

1-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Хэмжээ ба шаардлага		
		1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг
0	1	2	3	4
1	Гадаад байдал	Гадна талын байдал, өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хөнөөлт шавьжинд нэрвэгдээгүй, нахиа нь задраагүй, шилмүүс нь хатаагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр, эгц шулуун, бат бөх үндэс ихтэй, өсөлт сайтай байна.	адил	адил
2	Хэлбэр	Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчирүүд нь ишний нийт уртын 3/4-ийг эзэлсэн байна.	адил	адил
3	Хэмжээ:			
	а. Үндсэн мөчрийн тоо	10-15	8-10	6-8
	б. Титмийн тэлэлтийн голч, метрээр	1,2-1,5	0,9-1,2	0,6-0,9
	в. Суулгацын өндөр, метрээр	4-с доошгүй	2.5-4	1,5-2,5
4	Үндэс:	Өсөлт хөгжилт сайтай, 3-аас доошгүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндэсийг үржил шимтэй шороотой нь хамт авна.	адил	адил
	а. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн голч, метрээр	1,0-1,2	0,8-1,0	6-8
	б. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн зузаан метрээр	0,6-0,7	0,5-0,6	0,4-0,5

2.6 Шилмүүст модны суулгацын үндсэн ба салаалсан мөчрүүдийг доороос өөд нь шуухдаа холтосны гадаргаас 5-10 мм-ээс илүүгүй хэмжээнд огтолж, үлдсэн ёзоорыг тосон будгаар будаж, өвчин, хөнөөлт шавьжаас сэргийлэхийн зэрэгцээ, нарны гэрлийн хэт цонолтоос хамгаалж шохойгоор будсан байна.

2.7 Суулгацыг байрлуулах нүхний голч ба гүнийг энэ стандартын 1-р хүснэгтийн 4а ба 4б зүйлийн дагуу зэрэг тус бүрд заагдсан хэмжээгээр бэлтгэх ба түүний ёроолд нь үржил шимтэй хар шороог 20-оос 25 см-ээс доошгүй зузаантайгаар голд нь товойлгож асгасан байна. Суулгацыг байрлуулсаны дараа хар шороогоор сайн чигжиж, ханатал услах ба эгц ургуулахын тулд гувар ба титэмийн уулзварт 1 см-ээс доошгүй зузаан, 5 см-ээс багагүй өргөн даавуу буюу шуудайгаар мөчир,

холтосыг гэмтээхгүйгээр зөөллөн ороож төмөр утас буюу олсоор 3 зүгт ганхуулахгүйгээр тэлэн татаж бэхэлнэ.

Ойжуулалтад хэрэглэх шилмүүст модны суулгац

2-р хүснэгт

	Модны нэр	Суулгацын нас, жилээр	I зэрэг		II зэрэг	
			Үндэсний хүзүүвчийн бүдүүн /мм/	Тарьцын өндөр /см/	Үндэсний хүзүүвчийн бүдүүн /мм/	Тарьцын өндөр /см/
1	Нарс	4	4,5 ба дээш	30 ба дээш	3,5-4,5	20-30
		5	6,0 ба дээш	50 ба дээш	4,5-6,5	35-50
		6	8,0 ба дээш	70 ба дээш	6,5-8,0	55-70
2	Шинэс	4	4,5 ба дээш	30 ба дээш	3,5-4,5	20-30
		5	6,0 ба дээш	45 ба дээш	4,5-6,0	30-45
		6	8,0 ба дээш	75 ба дээш	6,5-8,0	50-75
3	Хуш	4	3,5 ба дээш	10 ба дээш	2,8-3,5	8-10
		5	4,5 ба дээш	15 ба дээш	3,5-4,5	12-15
		6	6,0 ба дээш	20 ба дээш	4,5-6,0	16-20
4	Гацуур	4	3,0 ба дээш	12 ба дээш	2,8-3,0	8-12
		5	5,0 ба дээш	16 ба дээш	3,0-4,9	12-16
		6	7,0 ба дээш	25 ба дээш	5,0-7,0	18-25
5	Жодоо	4	3,0 ба дээш	10 ба дээш	2,6-2,8	8-10
		5	4,5 ба дээш	15 ба дээш	3,0-4,5	13-15
		6	6,0 ба дээш	20 ба дээш	4,6-6,5	17-20

3 Суулгацыг хүлээн авах

3.1 Нийлүүлэгчээс хүлээн авах суулгацын чанарыг энэ стандартын шаардлагын дагуу нэг бүрчлэн шалгаж хүлээн авах ёстой.

3.2 Суулгацын чанар нь энэ стандартын шаардлага хангахгүй бол нийлүүлэгчээс хүлээн авахыг зөвшөөрөхгүй.

3.3 Хэсэг бүхэнд суулгацын паспорт дагалдах ёстой. Паспортыг хавсралтын дагуу хийнэ.

MNS 6139 : 2010

4 Хадгалах, савлах, тээвэрлэх

4.1 Суулгацын үржил шимтэй шороо бүхий үндэстэй хэсгийн өөрийн чийгийг алдагдуулахгүйгээр нүх, шуудуунд хийж хадгалах ба хөлдөөх болон чийг ууршихаас хамгаалж малын чийгтэй бууц, хар шороогоор хучвал зохино.

4.2 Энэ стандартын 1-р хүснэгтийн 4а ба 4б зүйлд заасан хэмжээгээр суулгацын шороотой хэсгийг шуудай буюу модон хайрцагт хийж савлана.

4.3 Авто машинаар суулгацыг тээвэрлэхдээ машины тэвшний ёроолд 40- 50 см үртэс эсвэл 25-30 см зузаантай хар шороо, малын бууц, дэвсэж зөөллөнө. Тээвэрлэхдээ үндсийг зохих материалаар хучиж, услаж тээвэрлэнэ. Суулгацыг суулгах хүртлэх хугацаанд тогтмол чийгтэй байлгана. Нэгдүгээр зэргийн суулгацын үндэстэй талыг нь жолоочийн бүхээг рүү харуулж хэвтүүлээд суулгацын үзүүрийн дамнах хэсгийг 5 см-ээс доошгүй зузаантай зориулалтын материалаар зөөллөж тээвэрлэнэ.

4.4 Авто машинд хоёр ба гуравдугаар зэргийн суулгацыг босоо байдлаар ачиж хооронд нь ганхуулахгүйгээр мод нэг бүрийг холбон мөн дээрхийн адил тэвшний ёроолд зөөлөвч дэвсэж ачих ёстой.

4.5 Суулгацыг 8 цагийн дотор тээвэрлэн хүргэж суулгасан байна.

4.6 Суулгацыг авах, суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтлана.

4.7 Суулгацын зэрэг бүхэнд хавсралтад дурьдсан паспортыг дагалдуулна.

ТӨГСӨВ.

**ХАВСРАЛТ
/Норматив/**

ПАСПОРТЫН №

Суулгацын нэр _____

(суулгацын төрөл, зүйл, нас, хэсэг дахь ширхэг)

Өгсөн _____

(мод үржүүлгийн газар, ойгоос)

1. Чанарын үзүүлэлтүүд

Суулгацын чанарын анги	Суулгацын техникийн нөхцөл буюу стандартын нэр ба дугаар	Суугацын тоо	
		ширхэгээр	Бүх хэсэг дэх %
I			
II			
III			

Суулгацыг ухаж авсан хугацаа
явуулсан хугацаа

Ой хамгаалагчаас суулгацыг явуулахыг зөвшөөрч олгосон баримт
(ой хамгаалагчийн нэр, он, сар, өдөр №...)

2. Гарал

Суулгац сонгон авсан газар (мод үржүүлгийн газар, аймаг, сум, газрын нэр)
Паспорт № суулгацыг хэн хэдийд өгсөн

3. Ургуулах нөхцөл

Мод үржүүлгийн газрын нэр ба орших газар нь:
Мод үржүүлгийн газрын хөрс
Суулгацын өвчин, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн байдал ба цаг уурын нөлөөллийн тухай тэмдэглэл
Паспорт олгосон онсар өдөр
Байгууллагын удирдагч
Хариуцлагатай мэргэжилтэн

2010 он сарөдөр